

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН  
2019 ОНЫ ЗУРГААДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
/2019.05.26-2019.06.15/

2019 оны 06 дугаар сарын 16-ний өдөр

Дорнод аймаг

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хийгдэх ажил	Биелэлт	Хувь
1	2	3	4	5
Нэг. Захиргаа, удирдлагын чиглэлээр				
1	Орон нутгийн өөрөө удирдах төрийн захиргааны болон хууль хяналтын бусад байгууллагаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөн олон нийтийн ажилд оролцох	а) Холбогдох албан хаагч нарыг хамруулах б) Шаардлагатай мэдээ, мэдээллийг харилцан солилцох,	Дарга Б.Тамир нь Иргэний нисэхийн ерөнхий газрын Дорнод аймаг дахь нисэх буудлаас зохион байгуулах “Онцгой байдлын үед ажиллах журмын КОД-7” сэдэвтэй бүрэн хэмжээний дасгал сургуулилтын бэлтгэл ажлын хүрээн дэх уулзалтад 6 дугаар сарын 11-ний өдөр оролцож санал бодлоо солилцсон. Даваа гараг бүрийн өглөө 8 цагт зохион байгуулагддаг Дорнод аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд газрын дарга биечлэн сууж хурлаар яригдсан орон нутгийн талаарх мэдээ мэдээллийг албан хаагчдад танилцуулсан	100%
2	Байгууллагын даргын болон бусад холбогдох нэгжээс ирүүлсэн үүрэг даалгавар, албан даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг гаргаж хүргүүлэх	а) Албан хаагчдад хүргүүлж, үүрэг даалгавар өгөх б) Хэрэгжилтийг тухай бүр хангах в) Холбогдох албан тушаалтанд тайлагнах	Байгууллагын даргын 2019 оны “Баримт бичгийн нууцлалын үзүүлэлт сэдэвт мэргэшүүлэх сургалт зохион байгуулах” Б/135 дугаар тушаал, Д.Оюунчимэгт чөлөө олгох тухай” Б/138, “Сургалт зохион байгуулах тухай” А/207 дугаар тушаалуудыг хүлээн авч зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Орон нутаг дахь Газрын даргын эрх хэмжээ, нийгмийн баталгааг хангах хүрээнд албан хаагчаас гаргасан хүсэлтийн дагуу Зүүн бүс дэх газрын даргын “Б.Одмаад зардал нөхөж олгох тухай” Б/07 тушаалыг батлан хэрэгжүүлэн ажилласан. Захиргаа удирдлагын газрын даргаас ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу нийт төрийн албаны шинэчилсэн анкетыг бүх албан хаагчаар бөглүүлж хүргэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мэргэжилтэн Д.Оюунчимэгийн чөлөө хүссэнтэй холбоотой 2018, 2019 онуудад авсан чөлөө, ээлжийн амралтын талаарх бүртгэл судалгааг хүргүүлсэн. Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст бүсийн газрын 05 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, байгууллагын даргын 2017, 2018, 2019 оны	100%

			албан даалгавруудын биелэлт, 07 дугаар сард хийх ажлын төлөвлөгөө зэргийг тус тус хүргүүлсэн.	
Хоёр. Сургалтын чиглэлээр				
3	Төвөөс зохион байгуулагдах сургалт, зөвлөгөөнд оролцох	а) Холбогдох албан хаагчийг хамруулах б) Сургалтын дүнг илтгэх хуудсаар танилцуулах	Мэргэжилтэн Г.Намуунзаяа байгууллагын даргын 2019 оны Б/135 дугаар тушаалаар баталсан “Баримт бичгийн нууцлалын үзүүлэлт” сэдэвт сургалтад 06 дугаар сарын 03-аас 06-ны өдрүүдэд Улаанбаатар хотод байгууллагын төвд хамрагдаж амжилттай суралцан гэрчилгээ авсан.	100%
Гурав. Нийгмийн баталгааг хангах чиглэлээр				
6	Албаны байрны гадаа дугуйн зогсоолтой болох	а) Эд материалын тооцоо гаргах б) Зогсоол хийлгэж байрлуулна в) Үг дүнг удирдлагад танилцуулах	Урин дулаан болж унадаг дугуйгаар хөдөлгөөнд оролцох явдал ихэссэн тул албаны байрны гадаа дугуйн зогсоолтой болох ажлыг төлөвлөгөөнд тусгасны дагуу судалж үнийн санал авч захиалга өгөөд байна.	100%

ТАНИЛЦСАН:  
ГАЗРЫН ДАРГА

Б.ТАМИР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

С.МӨНХЖАРГАЛ